



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.05.29 № 30

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай
хуулийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 2.1 дэх хэсэгт “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, 2.5 дахь хэсэгт “төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх”, 2.7 дахь хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэж Засгийн газрын чиг үүргийг тодорхой заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталснаар залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн оролцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т залуучууд руу чиглэсэн арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдийг тусгасан байна.

Гэвч дээрх эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд хийгдсэн арга хэмжээний үр дүн тодорхой бус байгаа тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу дараах асуулгыг тавьж байна.

1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө;

2.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсанаас хойш хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий нийт хэдэн төрийн албан хаагч холбогдох яам, агентлаг бусад засаг захиргааны нэгжүүдэд ажиллаж байгаа талаарх мэдээлэл;

3.Хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр жил бүрийн батлагдсан төсөв, түүний зарцуулалтын талаарх мэдээллийг төсөл, хөтөлбөр тус бүрээр дэлгэрэнгүйгээр (урсгал зардал, үйл ажиллагааны зардал гэх мэт);

